



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Онгон арвижих ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: СБА-2023/05/НА-СТА-ОНӨ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баруун-Урт 2023 он</p>	<p>Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 70518396 Цахим хаяг: <a href="mailto:narantuyam@audit.gov.mn">narantuyam@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Г.Даваа Утас: 70512123 Цахим хаяг: <a href="mailto:davaag@audit.gov.mn">davaag@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: Ө.Золзаяа Утас: 70512127 Цахим хаяг: <a href="mailto:zolzayau@audit.gov.mn">zolzayau@audit.gov.mn</a></p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	8
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	10
4.1 Ерөнхий зүйл .....	10
4.2 Материаллаг байдал.....	10
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	11
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	11
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	11
4.5.1 Завсрын аудитын талаар .....	11
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	12
5.1 Албан шаардлага .....	12
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	12

**Товчилсон үгийн жагсаалт**

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс: 70518396  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

СҮХБААТАР АЙМГИЙН ОНГОН  
АРВИЖИХ ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ  
М.ЗОРИГБААТАР ТАНАА

2023.03.28 № 159  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Онгон арвижих ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Онгон арвижих ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

“Онгон Арвижих” ОНӨААТҮГ нь 2022 онд нийт 17-н орон тоотой үйл ажиллагааг хэвийн явуулсан бөгөөд цалингийн зардалд 108,868.6 мянган төгрөг зарцуулсан байна.

### Аудитын гол асуудал

Гүйцэтгэлээр 312,177.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 316,683.6 мянган төгрөгийн зардал гарган 4,506.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

### Бусад асуудлын хэсэг

Онгон сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 05 дугаар тогтоолоор “Онгон арвижих” ОНӨААТҮГ-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан боловч гүйцэтгэл, үр дүнг нь дүгнээгүй байна.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D:/Bichig hereg/2023/A4 toot

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>77,593,463.96</b>	<b>77,743,283.60</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>45,501,067.96</b>	<b>59,490,694.91</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>45,501,067.96</b>	<b>59,490,694.91</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>45,501,067.96</b>	<b>59,490,694.91</b>
31213	Арилжааны банк дахь харилцах	45,501,067.96	59,490,694.91
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>10,793,836.00</b>	<b>1,778,176.00</b>
33401	Дансны авлага /ТӨҮГ/	10,793,836.00	1,778,176.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>21,298,560.00</b>	<b>16,474,412.69</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>21,298,560.00</b>	<b>16,474,412.69</b>
35420	Аж ахуйн материал	4,144,380.00	6,113,586.70
35440	Түлш, шатах тослох материал	10,028,200.00	3,299,999.99
35470	Бусад хангамжийн материал	7,125,980.00	7,060,826.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,653,160,367.47</b>	<b>1,820,775,119.44</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,653,160,367.47</b>	<b>1,820,775,119.44</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,648,572,467.47</b>	<b>1,816,236,719.44</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,763,966,948.00	1,812,965,609.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-122,364,268.72	-184,502,769.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	100,969,400.00	284,669,400.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-100,969,400.00	-102,500,233.33
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	5,774,700.00	5,774,700.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-2,229,444.48	-2,759,111.90
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	5,384,000.00	5,384,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-2,320,883.33	-3,097,683.33
39214	Бусад үндсэн хөрөнгө	732,600.00	732,600.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-371,184.00	-429,792.00
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>4,587,900.00</b>	<b>4,538,400.00</b>
39303	Бусад биет бус хөрөнгө	5,528,400.00	5,528,400.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-940,500.00	-990,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,730,753,831.43</b>	<b>1,898,518,403.04</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,574,861,133.88</b>	<b>1,747,131,944.63</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,574,861,133.88</b>	<b>1,747,131,944.63</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>5,000,240.22</b>	<b>5,205,157.27</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	114,075.00	0.00
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>4,886,165.22</b>	<b>5,205,157.27</b>
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	4,886,165.22	5,205,157.27
<b>41400</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>1,569,860,893.66</b>	<b>1,741,926,787.36</b>
41440	Бусад урьдчилж орсон орлого	1,569,860,893.66	1,741,926,787.36
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>155,892,697.55</b>	<b>151,386,458.41</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>155,892,697.55</b>	<b>151,386,458.41</b>
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	13,038,400.00	4,538,400.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>142,854,297.55</b>	<b>146,848,058.41</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	132,589,736.78	151,354,297.55
51220	Тайлант үеийн үр дүн	10,264,560.77	-4,506,239.14
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,730,753,831.43</b>	<b>1,898,518,403.04</b>

### 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	156,700,297.43	105,954,744.28
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	156,700,297.43	105,954,744.28
120	Нийтлэг татварын бус орлого	156,700,297.43	105,954,744.28
120005	Түрээсийн орлого	1,900,000.00	1,710,000.00
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	304,771,385.21	310,467,358.02
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	149,971,087.78	206,222,613.74
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	146,435,736.66	110,460,983.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	146,435,736.66	110,460,983.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	146,435,736.66	110,460,983.42
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	116,088,134.37	85,135,451.59
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	84,460.00	82,900.00
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	114,863,167.62	85,052,551.59
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	1,140,506.75	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,347,602.29	25,325,531.83
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	30,347,602.29	25,325,531.83
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	10,264,560.77	-4,506,239.14
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	10,264,560.77	-4,506,239.14

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,038,400.00	0.00	132,589,736.78	145,628,136.78
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,038,400.00	0.00	132,589,736.78	145,628,136.78
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	10,264,560.77	10,264,560.77
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,038,400.00	0.00	142,854,297.55	155,892,697.55
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	13,038,400.00	0.00	142,854,297.55	155,892,697.55
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-8,500,000.00	0.00	8,500,000.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,538,400.00	0.00	151,354,297.55	155,892,697.55
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-4,506,239.14	-4,506,239.14
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,538,400.00	0.00	146,848,058.41	151,386,458.41

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	317,161,580.03	344,772,966.97
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	317,161,580.03	344,772,966.97
120	Нийтлэг татварын бус орлого	317,161,580.03	344,772,966.97
120009	Бусад орлого	2,853,115.00	1,595,000.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	314,308,465.03	343,177,966.97

II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	288,059,026.01	330,783,340.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	288,059,026.01	330,783,340.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	288,059,026.01	330,783,340.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	88,986,705.00	94,224,709.00
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	88,986,705.00	94,224,709.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,623,405.42	27,528,496.21
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	25,623,405.42	27,528,496.21
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,338,772.51	61,059,487.81
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	59,338,772.51	61,059,487.81
2104	Хангамж, бараа материалын зардал	80,142,380.00	105,861,834.43
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	78,518,069.00	102,915,212.61
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	1,624,311.00	2,946,621.82
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,967,763.08	42,108,812.57
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	32,967,338.08	35,978,984.57
210817	Даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	322,725.00	0.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	677,700.00	6,129,828.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	29,102,554.02	13,989,626.95
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	3,149,800.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,149,800.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,149,800.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,149,800.00	0.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-3,149,800.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	25,952,754.02	13,989,626.95
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	19,548,313.94	45,501,067.96
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	45,501,067.96	59,490,694.91

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Эдийн засгийн үндсэн Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 он	
			төлөвлөгөө	гүйцэтгэл
1	<b>Нийт орлого: Үүнээс:</b>	мян.төг	325,405.6	312,177.4
1.1	Дулаан үйлдвэрлэлээс	мян.төг	320,285.6	310,467.4
1.2	Туслах үйлчилгээнээс	мян.төг	5,120.0	1,710.0
2	<b>Нийт зардал Үүнээс:</b>	мян.төг	317,198.2	316,683.6
2.1	Удирдлагын зардал	мян.төг	177,123.2	179,954.4
3	Үйл ажиллагааны үндсэн зардал	мян.төг	140,075.0	136,729.2
4	Татварын өмнөх ашиг алдагдал	мян.төг	8,207.4	(4,506.2)
6	Цэвэр ашиг алдагдал	мян.төг	4,597.3	(4,506.2)
7	Нийт ажиллагсдын тоо		17.0	17.0
8	Нийт цалингийн сан	мян.төг	123,350.0	108,868.6
9	Нэг ажилтны дундаж цалин	мян.төг	7,255.9	6,404.0
11	Борлуулалтын нэг төгрөгт ноогдох зардал өссөн буурсан		1.0	1.0
12	Нийт авлага	мян.төг	1,093.0	1,778.2
13	Нийт өглөг	мян.төг	6,102.0	5,205.2

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Компани/ТӨҮГ, түүний үйл ажиллагаа**

Онгон арвижих ОНӨААТҮГ-ийн зорилго нь хэрэглэгчдийг дулааны эх үүсвэрээр найдвартай, зохицуулалттай үнээр хангах, эрхлэх үйл ажиллагаанд тогтоосон нөхцөл, шаардлагыг чандлан биелүүлж ажиллах гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд үйл ажиллагааны чиглэлийг төрийн захиргааны байгууллагад үйлчилгээ үзүүлэх, дулаан түгээх үйл ажиллагаа гэсэн 2 төрлөөр тодорхойлсон байна.

#### **3.2 ОНӨААТҮГ-ын гадаад, дотоод орчин**

Байгууллагын Улсын бүртгэлийн гэрчилгээнд Ongon арвижих ОНӨААТҮГ хэлбэрээр 100 хувийн төрийн өмчлөлтэй, Ongon суманд харьяалагдаж, үйл ажиллагаа хэрэгжүүлж байна.

Онгон арвижих ОНӨААТҮГ-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сумын төвийн хүн ам, байгууллага, аж ахуйн нэгжид стандартын шаардлага хангасан цэвэр усан хангамжийг бий болгох, усыг түгээх, ашиглалт, засвар үйлчилгээг хангах
- Хэрэглэгчийн хэрэглээний цэвэр усны алдагдлыг бууруулах, цэвэр усанд стандартын дагуу лабораторийн шинжилгээ хийлгэх
- Уст цэг, түгээх байрны ашиглалт, засвар үйлчилгээг хангах
- Бохирдсон усыг зохих стандарт шаардлагын дагуу зайлуулах, цэвэрлэх байгууламжийн ашиглалтыг хангах, засвар үйлчилгээг хийх
- Хэрэглэгчдэд дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах, дулаан алдагдлыг бууруулах
- Даралттай шугам хоолой, ЦТП-ий засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ
- Нийтийн эзэмшлийн барилга байгууламж, зам талбай, шугам сүлжээ, техник тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ, технологийн шинэчлэлт хийх, түүнийг зориулалтын дагуу ашиглах
- Сумын төвийн хуурай хог хаягдлыг стандартын хүрээнд зайлуулах
- Үйлдвэрийн газар нь үндсэн үйл ажиллагаанаас гадна хуулиар хориглоогүй бусад бизнесийн үйл ажиллагааг явуулж орлого ашгаа нэмэгдүүлэхийн төлөө ажиллаж болно.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Онгон арвижих ОНӨААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Онгон арвижих ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Онгон арвижих ОНӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн бөгөөд өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 167,614.8 мянган төгрөгөөр буюу 10.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	45,501.1	59,490.7	13,989.6
Авлага	10,793.8	1,778.2	(9,015.7)
Бараа материал	21,298.6	16,474.4	(4,824.1)
Үндсэн хөрөнгө	1,653,160.4	1,820,775.1	167,614.8
Нийт хөрөнгө	1,730,753.8	1,898,518.4	167,764.6
Өр төлбөр	1,574,861.1	1,747,131.9	172,270.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	155,892.7	151,386.5	(4,506.2)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,730,753.8	1,898,518.4	167,764.6

Харилцах дансны үлдэгдэл 59,490.7 мянган төгрөг болж 30.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Авлагын үлдэгдэл 1,778.2 мянган төгрөг болж 9,015.7 мянган төгрөгөөр буурсан нь айл өрх, ААНБ-ын усны хэрэглээ, дулааны төлбөрийг төрөөс санхүүжүүлсэнтэй холбоотой 2021 оны 12 сарын авлагыг барагдуулсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөнд үнэ төлбөргүй 232,698.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, хөрөнгийн элэгдлийн зардлаар буурсан нь нөлөөлжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэлд 1,747,131.9 мянган төгрөгийн өр төлбөр байна. Өр төлбөрийн хэмжээ өмнөх оноос 172,270.8 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг урьдчилж орсон орлогоор бүртгэсэн бөгөөд тус хөрөнгө элэгдлийн зардлаараа буурсан нь нөлөөлсөн байна.

### **3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Онгон арвижих ОНӨААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Онгон сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 05 дугаар тогтоолоор “Онгон арвижих” ОНӨААТҮГ-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 325,405.6 мянган төгрөгөөр, нийт зардлыг 338,018.9 мянган төгрөгөөр, 7,386.7 мянган төгрөгийн алдагдалтай байхаар тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 312,177.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 316,683.6 мянган төгрөгийн зардал гарган 4,506.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 312,177.4 мянган төгрөг болж төлөвлөснөөс 13,228.2 мянган төгрөг буюу 4 хувиар буурсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 316,683.6 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 514.6 төгрөг буюу 0.2 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Онгон арвижих ОНӨААТҮГ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ө.Золзаяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Онгон арвижих ОНӨААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 288,056.0 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 5,761.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,032.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1<sup>1</sup>-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд уг зардлууд 1,720.7 мянган төгрөгөөр өссөн байна. Үүнд бензин шатахууны үнэ өмнөх онтой харьцуулахад нэмэгдсэн нь нөлөөлжээ.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих мэдээллийг бүрэн оруулсан байна.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай болон бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Онгон арвижих ОНӨААТҮГ-т завсрын аудит хийгээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	156.8	1	156.8	100
Албан шаардлага	1	3,996.7	1	3,996.7	100
Зөвлөмж	1	698,529.8	1	698,529.8	100
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>702,526.3</b>	<b>3</b>	<b>702,526.3</b>	<b>100</b>

<sup>1</sup> байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 21,927.2 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс алдааг дахин давтан гаргахгүй байх албан шаардлага өглөө.

### 5.1 Албан шаардлага

- Нүүрсний тээврийн хөлсийг Зам тээвэр, хөгжлийн сайдын тушаалаар тогтоосон тарифаас 4,369.6 мянган төгрөгөөр илүү бодож олгосон.
- Өмнөх онд өглөгөөр тайлагнаагүй нүүрсний үнэ, тээврийн хөлсөнд 17,557.6 сая төгрөгийг зарцуулж, орлого үр дүнгийн тайланд зардал илүү илэрхийлсэн.

Энэ нь нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь / Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна/, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх / Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ/, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5 дахь /хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх/, Зам тээврийн хөгжлийн сайдын 2022 оны А/233 тушаалын 2-р хавсралтыг тус тус зөрчсөн байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нүүрсний тээврийн хөлсийг илүү бодож олгосон	1	4,369.6	-	-	1	4,369.6	-	-	-	-	-	-
Өмнөх онд үүссэн өглөгийг санхүүгийн тайланд илэрхийлээгүй	1	17,557.6	-	-	1	17,557.6	-	-	-	-	-	-
Дүн	2	21,927.2	-	-	2	21,927.2	-	-	-	-	-	-

<sup>2</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,